

Ээлжит хичээлийн хөтөлбөр-2

Хамрах хүрээ: 6-р анги

Сэдэв: Төвийн тэгш хэм

Хугацаа: 40 минут




Зорилго: Дүрсийн төвийн тэгш хэмийн хувиргалтын шинж чанарыг мэдэх

Зорилт:

- Цэгийг төвийн тэгш хэмээр хувиргах
- Шулууныг төвийн тэгш хэмээр хувиргах
- Дүрсийг төвийн тэгш хэмээр хувиргах
- Агуулга:

Өмнө судалсан агуулга	Цаашид судлах агуулга
- Төвийн тэгш хэмийн талаар судалж байгаагүй. Энэ нь шинэ ойлголт юм.	- Төвийн тэгш хэмийн дараалсан хувиргалт хийх

Цагийн төлөвлөлт:

Хичээлийн бүтцийн явц	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
Хичээл зохион байгуулалт - 1 минут	- Сурагчидтай мөндлэнэ - Хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэнэ.	- Багштай мөндлэнэ - Сурагчид хичээлийн бэлтгэл байдлыг хангана.
Сэргээн санах (Сэдэлжүүлэлт) - 5 минут	Алхам 1 А цэгийг О цэгийн хувьд тэгш хэмээр хувиргаарай	
Шинэ хичээл - 15 минут	Алхам 2 - Шулууныг О (0,0) цэгийн хувьд тэгш хэмээр хувиргаарай. Чиглүүлэх асуулт (Шулууны зөвхөн эхлэл ба төгсгөлийн цэгийг ашиглан шулууныг О цэгийн хувьд тэгш хэмээр хувиргаж болох уу?) Алхам 3 Дүрсийг өгсөн цэгийн хувьд тэгш хэмтэй хувиргаарай. (Шулууныг О цэгт төвтэй тэгш хэмээр хувиргасан санааг давтаарай)	
Бататгах - 10 минут	ABC гурвалжин О цэгийн хувьд $A^1B^1C^1$ гурвалжинтай тэгш хэмтэй. а. Хэрэв $AB = 4$, $B^1C^1 = 3$ бол A^1B^1 , AC , A^1C^1 зайг олоорой. б. ABC өнцөг ямар өнцөгтэй тэнцүү вэ?	

Үнэлгээ - 5 минут	Дүрсийг хэрхэн зөв хувиргасан байдлыг үнэлнэ. Цэг, хэрчмийг тэгш хэмээр хувиргах арга барил эзэмшсэн сурагч дүрсийг хувиргаж чадна.
Дүгнэлт - 2 мин	Асуулт Төвийн тэгш хэмээр дүрс ямар дүрсэд шилжиж байна вэ? Төвийн тэгш хэмээр өөрөө өөртөө шилждэг дүрсийг төвийн тэгш хэмтэй дүрс гэнэ.
Гэрийн даалгавар - 2 минут	Сурах бичгийн хуудас дасгал бодлогыг бодох Сурагчдын шинэ мэдлэгийг бататгах 1 болон 2 түвшний урьдчилан бэлтгэсэн даалгавар болон сурах бичгийн даалгавруудыг өгнө. Тухайн бодлогыг бодсон аргаа тайлбарлан бичиж ирэхийг сануулна.